

БАГА ОВРЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

Бага оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн судалгаа явуулж, тендерийн баримт бичгийг стандартын дагуу боловсруулан 2 дугаар сард Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Уг тендерийн сонгон шалгаруулах ажлын хэсэгт Төслийн менежер орж, бусад гишүүдийн хамт худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийг 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр зарлаж, 3 дугаар сарын 14 - ний өдөр нээсэн боловч нэг ч компани санал ирүүлээгүй тул тендерийг дахин зарлахаар гишүүд шийдвэрлэсэн. Тендерийн дахин сонгон шалгаруулалтын нээлтийн ажиллагаа 4 дүгээр сарын 16 нд болж, хоёр компани санал ирүүлснээс “Глобал бизнес” Линк ХХК шалгарч, 2018 оны 5 дугаар сарын 25 ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулсан. Хөдөө аж ахуйн зориулалт бүхий анжис, хүнд диск, роторт сийрүүлэгч, төмс үрлэгч, төмс хураагч, усалгааны систем, нарийн ногооны үрлэгч, хор цацагч төмсний кон болон 5 тоннын даацтай өргөгч кран зэрэг 10 төрлийн тоног төхөөрөмжүүд графикийн дагуу хугацаандаа нийлүүлэгдсэн. НХХААГ-ын даргын тушаалаар томилогдсон тус газрын хэлтсийн дарга Ц.Төмөртулгаар ахлуулсан хүлээн авах комисс 2018 оны 10 дугаар сарын 02 –ны өдөр талбай дээр ажиллаж, техник тоног төхөөрөмж нэг бүрийг нэг бүрчлэн угсруулан ажиллуулж, акт үйлдэж хүлээн авсан. Мөн Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2018 оны 10 дугаар сарын 15 ны өдрийн 2/1582 тоот албан бичгийн дагуу дээрхи техник, тоног төхөөрөмжүүдийг байгууллагын бүртгэлд хүлээн авсан.



